



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/122

Ховд

ГЗарим үйлчилгээний байгууллагуудын үйл
ажиллагааг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “ж”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн, Ховд аймгийн Онцгой комиссын хурлын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, кафе, ресторан, караоке, зоогийн газруудын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаагаар түр зогсоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

